

ХЯТАД-МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, ХУДАЛДААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БОЛОН ИРЭЭДҮЙН ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА

*Э. Наран**

Хятад, Монгол хоёр орон бол найрсаг түнш мөн. 1989 онд хоёр орны харилцаа хэвийн болсноос хойш, хоёр тал дээд түвшинд харилцан айлчлал үргэлж хийхийг баримталж, онцгойлон 2003 онд дарга Ху Жиньтао Монгол Улсад айлчлах хугацаанд хоёр тал Хятад, Монголын найрсаг харилцан итгэлцсэн түншлэлийн харилцааг байгуулан хөгжүүлж, хоёр орны харилцааг шинэ хөгжлийн төвшинд хүргэхээр зарласан юм. Сүүлийн жилүүдэд хоёр талын хамтын чармайлтын үр дүнд Хятад, Монголын эдийн засаг, худалдааны харилцааны хөгжил маш хурдан байж, шинэ өндөр төвшнийг үүдсэн байна.

Нэг. Хятад улс бол Монгол Улсын хамгийн том худалдааны түнш мөн.

1999-2005 оны хооронд Хятад улс нь 7 жилийн хугацаанд тасралтгүй Монголын худалдааны хамгийн том түнш орон байгаа юм. Мөн Хятад улс нь Монгол Улсын экспортод 1-р байр эзэлж импортын хувьд 2-р байр тус тус эзэлдэг. Монголын Үндэсний статистикийн газрын мэдээгээр, 2005 онд Монгол Улс нь 97 улс орон болон бүстэй худалдааны ажиллагаа өрнүүлж, гадаад худалдааны экспорт, импортын нийт хэмжээ нь 2 тэрбум 249 сая ам.долларт хүрсэн нь сүүлийн жилүүдийн хамгийн өндөр үзүүлэлт юм. Хятад, Монголын худалдааны нийт хэмжээ нь 2004 оны байдлаар 671 сая ам.долларт хүрч хамгийн өндөр төвшинд хүрч байсан бөгөөд 2005 онд 821.5 сая ам.долларын хэмжээтэй болж, Монголын гадаад худалдааны нийт эргэлтийн 38 хувийг эзэлсэн байна.

Экспорт : Монгол Улс нь 72 улс орон болон бүсэд экспорт гаргасан байна. Үүний дотор Хятадад экспортлосон хэмжээ нь 514.2 сая ам.доллар байж, Монгол Улсын гадаад худалдааны экспортын нийт хэмжээний 48.3 хувийг эзэлж, тэргүүн байранд орсон байна.

Монгол нь Хятадад гол төлөв уул уурхайн бүтээгдэхүүн, нефть, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн зэргийг экспортлож байна. Эдгээр бараа бүтээгдэхүүний экспортлох үнэ нь өнгөрсөн жилээс ихээхэн өсч, гол нь олон улсын зах зээл дээр зэс, алт, нефть зэргийн үнэ тасралтгүй өссөний нөлөөг хүртсэнээс болсон юм.

1) 2005 онд Хятадад экспортлосон зэсийн баяжмалын хэмжээ нь 55.66 мянган тонн байж, тус оны үйлдвэрлэлийн хэмжээнийхээ 95.2

* Э.Наран - БНХАУ-ын Өвөр Монголын их сургуулийн Хөрш орон судлах хүрээлэн, доктор (Sc.D)

хувийг эзэлж, бараа нийлүүлсэн хэмжээ нь 310 сая ам.доллар байж, өнгөрсөн оньхоосоо дунджаар тонн бүрд 50 ам.доллар нэмэгдсэн байна.

2) 2005 онд Хятадад экспортлосон молибдений баяжмалын хэмжээ нь 2299 тонн байж, тус оны үйлдвэрлэлийн хэмжээ нь 95.9 хувийг эзэлж, бараа нийлүүлсэн хэмжээ нь 44 сая 799 мянган ам.доллар байж, өнгөрсөн оны мөн үеийн тонн бүрдээ 8906 ам.доллар байснаасаа 19488 ам.доллар болон үнэ нь эрс нэмэгдэж, үнийн өсөлтийн хэмжээ нь 2 дахин илүү болсон байна.

3) 2004 онд Хятадад экспортлосон нефтийн хэмжээ нь 180 мянган баррель байж, бараа нийлүүлсэн хэмжээ нь 6 сая 279.7 мянган ам.долларт хүрч байсан бол 2005 онд уг хэмжээ нь 164 мянган барель болон буурсан байна. Гэвч бараа нийлүүлсэн үнийн дүн нь 8 сая 52.7 мянган ам.доллар болж өсчээ.

4) 2005 онд Хятадад экспортлосон жоншны хэмжээ нь 852.1 мянган ам.доллар байж, өнгөрсөн оны мөн үеийхээсээ 6.6 хувиар өссөн байна. Жоншны үнэ дунджаар тонн бүрдээ 73 ам.доллараас 80 ам.доллар болсон байна. Монгол жоншныхоо бараг 48.5 хувийг нь Орост, 24.6 хувийг нь Украин, 15.7 хувийг нь Америкт, үлдсэн 11.2 хувийг нь бусад орнуудад экспортлож, харин Хятадад маш бага хэмжээгээр экспортолсон байна.

5) 2005 онд ямааны сайн ноолуур, хонины ноос болон адууны дэл, сүүл болон адууны арьс зэрэг 5 зүйлийн мал аж ахуйн бүтээгдэхүүнийг ч Хятадад экспортолж, хэмжээ нь 25 сая 478,9 мян.ам.доллар болсон нь өнгөрсөн оньхоос 27.8 хувиар өссөн байна.

Импорт: 2005 онд Монгол Улс нь нийт 91 улс орноос импортын бараа оруулсан бөгөөд Хятадын импортын хэмжээ нь 307.3 сая ам.доллар байж, Монголын импортын нийт хэмжээний 25.9 хувийг эзэлж, Оросын дараа 2-р байр эзэлсэн байна.

Монгол нь Хятадаас голдуу нефтийн бүтээгдэхүүн, зам тээврийн тоног төхөөрөмж, хүнсний бүтээгдэхүүн, жимс хүнсний ногоо, хөнгөн аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүн болон дунд, доод зэрэглэлийн амьдралын хэрэглээний бараа бүтээгдэхүүн зэргийг импортлож байна.

1) 2004 онд Монгол Улс нь Хятадаас 8.94 сая ам.долларын нефтийн бүтээгдэхүүн импортолж байсан бол, 2005 онд энэ хэмжээ нь 13.4 сая ам.долларт хүрч, 2004 оныхоос 65.8 хувиар нэмэгдсэн байна. Монгол Улс нь нийт хэрэгцээнийхээ 85 хувиас доошгүйг ОХУ-аас авдаг ба сүүлийн жилүүдэд Хятадаас импортлох нь их хурдан нэмэгдэх хандагатай болсон байна.

2) 2005 онд Монгол Улс нь Хятадаас 7.77 сая ам.долларын өртөг бүхий автобус болон зам засах машин, тоног төхөөрөмж, жижиг

суудлын машин болон ачааны машин импортолсон нь 2004 оныхоос бараг 5 дахин нэмэгдсэн байна.

3) 2005 онд Хятад улсаас 13.2 сая ам.долларын өртөг бүхий цагаан будаа, элсэн чихэр, гурил, төмс, ургамлын тос болон шар айраг зэргийг импортолсон нь 2004 оны оныхоос 19.3 хувиар буурсан байна. Үүнд гурилын импортын хэмжээ ихээр буурсан явдал нөлөөлсөн бөгөөд энэ нь Монголын талынхан Хятадаас оруулж байгаа гурилын чанар нь Орос болон бусад орныход хүрэхгүй гэж үзсэн байна. Сүүлийн жилүүдэд Хятадаас импортолсон төмс, хүнсний ногоо зэргийг химийн бордоо, бусад бүтээгдэхүүний хэмжээ эрүүл мэндэд хортой түвшинд байна хэмээн гадуурхах хандлага нэмэгдсэн байна.

Хоёр. Хятад улс бол Монголд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээгээр хамгийн том орон мөн.

1990-2005 оны хооронд нийт 75 улс орон Монголын 4814 төсөлд 1 тэрбум 441 сая ам. долларын хөрөнгө оруулсан байна. 2005 оны эцэс болтол, Хятад улс нь Монголын 2166 төсөлд хөрөнгө оруулж, Монголын бүхий л гадаад хөрөнгө оруулалтын нийт төслийн 45 хувийг эзэлсэн байна. Хөрөнгө оруулсан хэмжээ нь 681 сая байж Монголд орж ирсэн гадаад хөрөнгө оруулалтын 47.3 хувийг эзэлсэн байна. Зөвхөн 2005 онд шинээр 568 төсөл нэмэгдэж, хөрөнгө оруулалтын хэмжээ нь 235.8 сая ам.долларт хүрч, тус онд Монголын хүлээж авсан нийт гадаадын хөрөнгийн 75.6 хувийг эзэлсэн байна. 1998 оноос эхлэн Хятад улс нь Монголд хөрөнгө оруулалтын хэмжээгээр 8 жил тасралтгүй 1-р байр эзэлсэн байна. Тус үзүүлэлтээр 2-р байр Канад, 3-р байр Америк тус тус эзэлж байна. Харин Орос нь Монголд хөрөнгө оруулсан хэмжээгээрээ дөнгөж 6-р байр эзэлж байгаа бөгөөд үүнд Улаанбаатарын төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг, Эрдэнэтийн зэс, молибденийн уурхай болон Монросцветмет компани зэрэг ЗХУ-ын үед байгуулсан 3 том аж ахуй багтахгүй юм. Тус 3 аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн хэмжээ нь Монголын үндэсний нийт бүтээгдэхүүний 40 хувийг эзэлж, бараа бүтээгдэхүүний экспортын хэмжээ нь Монголын экспортын нийт хэмжээний 60 хувийг эзэлдэг. Оросын хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжүүд нь Монголын эдийн засагт жижиг, дунд үйлдвэрлэлд мөн л ихээхэн нөлөө үзүүлж байгаа юм.

2003 онд дарга Ху Жиньтао Монголд айлчлах хугацаанд хоёр тал Хятад, Монголын эдийн засгийн хамтын ажиллагаа нь гол төлөв байгалийн баялаг болон дэд бүтцийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх тохиролцоонд хүрсний дүнд, 2004 онд Хятад улсаас оруулсан нийт хөрөнгө оруулалтын 65.6% буюу 73.9 сая ам.доллар нь уул, уурхайн хайгуулын салбарт төвлөрч, өмнө нь нийтийн хоолны салбарт

хамгийн их хөрөнгө оруулж байсныг давж, 1-р байр эзэлсэн байна. 2005 онд уул, уурхай, геологи-хайгуулын салбарт оруулсан хөрөнгийн хэмжээ нь маш түргэн өсч 173 сая ам.долларт хүрч, 2004 оноос 134 хувиар өссөн бөгөөд 2005 онд Хятадаас Монголд оруулсан (235.8 сая ам. долл) хөрөнгийн нийт хэмжээний 74 хувийг эзэлсэн байна.

Гурав. Хятад, Монголын хилийн худалдаа болон бүс нутгийн худалдаа эрчимтэй явагдаж байна.

Хятад, Монголын хилийн худалдаа болон бүс нутаг хоорондын худалдаа бол хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг юм. 1985 оноос өмнө Өвөр Монгол, Шинжаан, Нинься зэрэг өөртөө засах район болон Хэбэй, Хэнань, Жилинь, Хармөрөн зэрэг муж, тэрчлэн өмнөд нутгийн хэсэг муж нь бүр Монголын холбогдох бүс нутаг болон байгууллага нэгжүүдтэй үр ашигтай хилийн хязгаар районы эдийн засаг, худалдааны ажиллагааг идэвхитэй өрнүүлсэн байна. Одоогоор Өвөр Монголын Өөртөө Засах Орон хэдийнээ Хятад, Монголын хилийн худалдаа болон эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны чухал тавцан болсон байна. 1983-2004 болтол, Өвөр Монгол болон Монгол Улс хоорондын хилийн худалдааны нийт хэмжээ 2 тэрбум ам.долларт хүрч, Хятад, Монголын худалдааны нийт хэмжээний хагасаас дээш болсон байна. 2004 оны эцэс болтол, хамтарч барьсан барилга байгууламж, ажиллах хүчний хамтын ажиллагаа болон төлөвлөгөө гэх зэрэг зорилгоор нийт 387 төсөл хэрэгжиж, хэлэлцээрийн нийт хэмжээ нь 660 сая ам. долларт хүрч, мөн ажиллах хүчний гадаад томилолт 8156 удаа хийгдсэн бөгөөд 20 сая ам.долларын тоног төхөөрөмж, материал хэрэгсэл зарцуулсан байна. Хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа нь өргөн хэрэглээний бараа болон түүхий материалаас өргөжөөд эд баялгийн нээн ашиглалт, боловсруулалт, угсралт, хөдөө аж ахуйн таримал, мал аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт болон барилга байгууламж зэрэг эдийн засаг, техникийн олон талын хамтын ажиллагаанд шилжсэн байна. Одоогоор Хятад-Монголын гадаад худалдааны хэмжээнд Өвөр Монгол 70 хувийг эзэлж байна.

2004 оны 10-р сард Хятадын Өвөр Монголын Засгийн газрын дарга Ян Жин төлөөлөгчдийн бүлгэмийн хамт Монгол Улсад айлчлах хугацаандаа хоёр тал цаашид үргэлжлүүлэн хоёр талын худалдааг өргөтгөж, бараа бүтээгдэхүүний төрөл зүйлийг нэмэгдүүлэхэд анхаарч, Өвөр Монгол нь Монголд хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх, Монгол Улсын уул, уурхайн эд баялгийг нээн ашиглаж, дэд бүтцийг сайжруулах, Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүс болон экспортын бааз суурь байгуулах зэрэг нааштай арга хэмжээ авахаар тохиролцсон байна. Хоёр талын хэлэлцээрийг цаашид биелүүлэхийн тулд 2005 оны

6-р сард Өөртөө Засах Орны Засгийн газрын орлогч дарга Улаан Өвөр Монголын хамтын ажиллагаа, солилцооны төлөөлөгчдийн хамт Монгол Улсад айлчилсан байна. Айлчлалын хугацаанд, хоёр тал хамтын ажиллагааны 16 хэлэлцээрт гарын үсэг зурсан бөгөөд хэлэлцээрийн өртгийн хэмжээ нь 300 сая ам. долларт хүрсэн байна. Энэ удаад батлагдсан хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд голдуу эдийн засаг, худалдаа, соёл урлаг, боловсрол, хэвлэл, нийтлэл зэрэг өргөн салбарыг хамарсан юм.

Дөрөв. Хятад, Монголын эдийн засаг худалдааны хамтын ажиллагааны ирээдүйн хөгжлийн чиг хандлага.

Одоогоор Хятад, Монгол хоёр орны харилцаа нь түүхэндээ хамгийн сайн үедээ ороод байна, хоёр талын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа урд өмнө байгаагүй эрчимтэй сайн хөгжлөө олсон байна. Энэ бол хоёр орны хамтаар чармайсны дүн мөн бөгөөд үргэлжлэн баримталж хөгжүүлэх нь чухал юм. Хоёр орны эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа улам цаашид гүнзгийрэн хөгжихийг түлхүү ахиулахын төлөө, хоёр талын ашигтай хүчин зүйл болон наазгай хүчин зүйлийг шинжилж анхаарсны үндсэн дээр цаашдын хөгжлийн зорилтыг тогтохоор дамжин хоёр тал харилцан ашигтай байх үр дүнд хүрэх хэрэгтэй.

1. Эерэг хүчин зүйл

Бүс нутгийн давуу тал: Хятад, Монгол хоёр орон 4709 километр урт хилийн шугамтай, Монгол Улс бол манай оронтой хил нийлж байгаа 14 хөрш орны дотор хамгийн урт хилийн шугамтай орон юм. Үүнд Өвөр Монголын Өөртөө Засах Орон болон Монгол Улс хоорондын хилийн шугам нь Хятад, Монголын хилийн шугамын 68.3 хувийг эзэлж байдаг. Энэхүү бүс нутгийн давуулаг хүчин зүйл нь хоёр орон эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа болон хил орчмын хамтын ажиллагаанд маш сайн дөхөм нөхцөл боломжийг олгосон юм.

Харилцан нөхөх давуу тал: Хятад, Монгол хоёр орны нийт бодит хүчний зөрөө болон эдийн засгийн бүтцийн зөрөө нь хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагаанд маш чанга харилцан нөхвөрлөх чанарыг бүрдүүлж байна. **Нэгд,** Монгол Улсын элбэг баян зэс, нүүрс, нефть болон бусад уул уурхайн баялаг болон Хятадын харьцангуй дэвшилттэй техник, туршлага, эрчим хүчний их хэмжээний эрэлт шаардлага: **хоёрт** Монголын элбэг баян мал аж ахуйн бүтээгдэхүүн болон манай орны харьцангуй дэвшилт арьс ноолуурын боловсруулах мэргэжил болон том зах зээл: **гуравт,** Монголын хөдөө аж ахуйн харьцангуй сул байдал болон үр тариа, хүнсний ногоо, жимс зэргийн шаардлага болон манай орны элбэг баян хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн,

боловсронгуй хөдөө аж ахуйн техник зэрэг нь харилцан нөхвөрлөх чанартай байдаг.

2. Сөрөг хүчин зүйл

Юуны өмнө, Монголын дэд бүтэц нь хоцронгуй, олон газарт ус, сахилгаан, зам харилцааны систем бүрэлдээгүй, иймээс их хэмжээний урдчилсан хугацааны хөрөнгө оруулалт чухал байж, маш их хүчир бэрхшээл болон эрсдэлтэй байдаг. **Дараа нь**, Монгол Улсын хууль дүрмийн орчин боловсронгуй биш, төрийн бодлого нь олон талын байж, хөрөнгө оруулагчийн ашиг тус баталгаагүй байдаг. Үүнээс гадна, Монголын уул уурхайн нээн ашиглах зөвшөөрлийн хамааралт эмх замбараагүй байж, засгийн газрын тохируулалтын хүчин чадал нь буурай байдаг. Сүүлийн үед нээж илрүүлсэн уул уурхайн ордын хайгуулын болон ашиглалтын зөвшөөрлийн гэрчилгээ –лицензүүд нь үндсэндээ аж ахуйн нэгж юм уу, хувь хүний гарт байдаг, зарим нээн ашиглаж болох уул уурхайд бас хязгаарлалт тавьдаг нь гадаадын хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн бэрхшээлийг ихээхэн нэмэгдүүлсэн байна. **Гуравт**, Монголын зарим аж ахуйн нэгж болон бизнесменүүдийн эзэгнэлтийн чадвар нь сул, итгэмжээр муу, гадаадад өгсөн амлалт болон хэлэлцээрээ үргэлж засаж өөрчилдөг. **Дөрөвт**, Хятадын зарим хүчин чадал нь хүрэлцэхгүй, олон улсын хамтын ажиллагааны чадвараар дутмаг аж ахуйн нэгжүүд Монголд дураараа эзэгнэлт хийж, зарим талаар хоёр орны хамтын ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна.

3. Цаашид анхаарбал зохих асуудлууд

Нэгд, хоёр тал эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны эрч хүчээ нэмэгдүүлнэ. Хятад, Монгол хоёр орны газар зүйн давуу тал болон хоёр талын эдийн засаг худалдааны маш чанга харилцан нөхвөрлөх чанарыг үндэслэн, эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны эрч хүчээ улам нэг алхам нэмэгдүүлж, Хятад улсын дарга Ху Жиньтаогийн Монголд айлчлах үед тохиролцсон “Эрчим хүчний нээн ашиглалт болон дэд бүтцийн байгуулалтыг хожмын хөгжлийн чухал салбар болгох” чухал нийтлэг ойлголтыг чармайн биелүүлж, хоёр талын эдийн засаг худалдааны хамтын ажиллагааг шинэ төвшинд гаргаж, харилцан ашигтай хамтаар хөгжих зорилгод хүрэх хэрэгтэй.

Хоёрт, хоёр талын засгийн газрын үүрэг гүйцэтгэх салбарын үйлдлийг дээшлүүлнэ. Монголын талаас авч хэлбэл, засгийн газар нь гол жолоодох үйлдэл гаргаж, холбогдох бодлого болон баталгаажлын арга хэмжээ тогтоон хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахын зэрэгцээ тэдгээр аж ахуйн нэгж болон хувь хүнийг хууль дүрэмд нийцсэн арга барилаар, зүй зохистой үнээр уурхайн эрхээ шилжүүлэхийг урамшуулбал зохино. **Хятадын талаас авч хэлбэл**, ойрын хугацааны ашиг сонирхол болон дунд урт хугацааны зорилтоо

сайн тохируулж, хугацаагаар урт, цар хүрээгээр их бөгөөд Монголын эдийн засагт ихээхэн нөлөөтэй байж хоёр талаараа ашиг олох хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлэх, түүнийг Хятад, Монголын эдийн засаг, худалдааны харилцааны урт хугацааны үр ашигтай хамтын ажиллагааны гол цогц болгох ёстой.

Гуравт, Өвөр Монголын Хятад-Монголын харилцаан дахь гүүрийн үүргийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Өвөр Монголын Өөртөө Засах Орны 6 аймаг хот, 15 хошуу нь Монгол Улсын 6 аймаг 26 сумтай хил залгаж байдаг. Хоёр орон нь эдүгээ нэгэнт 18 боомт нээсэн бөгөөд үүний 10 нь Өвөр Монголд байдаг. Өвөр Монголын бүс нутгийн болон боомтын давуу талыг ашиглаж Хятад-Монгол, Хятад-Оросын солилцоо болон хамтын ажиллагааны дунд гүүрийн үйлдлийг бадруулах ёстой.

Үүний зэрэгцээ, Хятад, Монголын харилцааны дунд Өвөр Монголын хүмүүнлэгийн давуу талыг чухалчлах хэрэгтэй. Өвөр Монголын соёлын их районыг байгуулах гэсэн ашигтай боломж тохиоллыг ашиглан, иргэн хоорондын солилцоог өрнүүлэх хэрэгтэй. Үүнд хоёр орны залуучууд багачууд хоорондын солилцоог өргөтгөн харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх, хоёр орны ард иргэдэд хоёр орны эдийн засаг, худалдаа, соёл зэргийн түргэн хөгжил, сайн сайхан хандлага болон хоёр орны урт хугацааны найрсаг түншийн харилцааны бодлогыг гүн ойлгуулах зэрэг агуулга багтаж байна.

Үүнээс гадна, онцолж хэлэхэд холбогдох байгууллага Монгол, Орост байгаа Хятадын харъяат нарын соёлын боловсрол болон ерөнхий боловсролыг анхаарч, тэдгээр бодит хүчин чадалгүй, улс орны дүр төрхийг гутаагч аж ахуйн нэгж болон хувь хүний гадаадад худалдааны ажиллагаа юм уу, бусад ажиллагаанд оролцохыг хориглох хэрэгтэй.